

技能実習生の友

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2022 оны 1 дугаар сар,
Өвлийн дугаар

Сэдэв

Япон хүний сэтгэлийг мангагаар дамжуулан мэдэж авъя. “Японы өвлийг зугаатай өнгөрөөх арга”

◇Цасны орон Ниппон -Цас их ордог механизм-

◇Японы шинэ жил -Осэчи рёри (Шинэ жилийн баярын зоог) болон Нанакуса-гаю (Долоон төрлийн ургамалтай цагаан будааны зутан)

Кокуго-но-мори “Ижил дуудлагатай ханз”

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Японы өвлийг зугаатай өнгөрөөх арга —



Хүйтэн улиралд ч янз бүрээр хөгжилдөж болно!

Японд өвөл болж, агаарын температур буурахаар цас ордог газар олон байдаг. Цас их ордог нутагт цана, снөүборд г.м өвлийн спорт түгээмэл байдаг. Японд “Юки-я-конко, Арарэ-я-конко” гэсэн үгээр эхэлдэг “Цас” гэдэг хүүхдийн алдартай дуу байдаг ба энэ нь олон хүмүүсийн танил дуу юм. Цас харахаар энэ дуу санаанд нь ордог хүмүүс ч олон байдаг тул интернетээр хайж үзээрэй. Мөн, өвлийн улиралд бие дулаацахуйц хоол идэж, биеэ хөргөхөөс сэргийлэх нь ч чухал. Эрүүл мэнддээ маш сайн анхаараарай.

“Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-ийг Ур чадварын дадлагажигч, суралцагчдад зориулан Япон дахь өдөр тутмын амьдралд хэрэг болох мэдээлэл болон Япон хэлний сургалтын материал, 4 нүхт манга зэргийг дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи хэл) дээр нийтэлдэг. Та бүхнийг сонирхон ашиглахыг урьж байна!



Цасны орон Ниппон -Цас их ордог механизм-

Таны амьдарч байгаа бүсэд цас ордог уу? Японд дэлхийд цөөхөн байдаг цас ихээр ордог бүс* байдаг ба гадаадын хэвлэл мэдээллээс гаргасан “Дэлхийн цас ихээр ордог хотуудын зэрэглэл”-ээр эхний байрнаас нь жагсаавал, Аомори хот, Саппоро хот, Тояма хот гэсэн Японы хотууд эхний 3 байрыг эзэлдэг гэж танилцуулагдсан тохиолдол ч байсан. Тэгвэл яагаад Японд цас ингэж ихээр ордог юм бол.

Юуны өмнө, Зүүн Ази болон Зүүн өмнөд Азид улирлын салхи (монсуун) гэдэг салхи салхилдаг ба зунд Номхон далай, Энэтхэгийн далайгаас эх газар руу, өвөлд эсрэгээрээ эх газраас далай руу салхилдаг. Тийм учраас өвөл болохоор, эх газраас Японы арал руу чиглэсэн хүйтэн, хуурай салхи салхилдаг ба энэ салхи дээгүүр нь дайрч өнгөрдөг Япон тэнгист “Цүшима урсгал” гэгдэх дулаан урсгал* урсдаг бөгөөд энэ урсгал нь их хэмжээний уур мананг* бий болгодог. Улирлын салхи нь энэ дулаан урсгалын дээгүүр дайрахдаа уур манантай нийлж үүл бүрэлдүүлдэг. Ингэж бий болсон үүл нь Японы аралд хүрэхээрээ, уул нурууны дагуу өндөрсөж явсаар, огцом хөрдөг. Энэ үед үүлэн доторх хүйтэн уур манан нь цас болж, Япон тэнгистэй хил залгаа нутгуудад их хэмжээний цас оруулдаг.

Япон тэнгистэй хил залгаа нутгуудын эсрэгээр, Канто болон Тоокай бүс зэрэг Номхон далайтай хил залгаа нутгуудад чийггүй болсон салхи уул даван хүрдэг тул, өвөлд хуурай, цэлмэг өдөр олон байдаг.

*Цас ихээр ордог бүс (Өвөл цас их ордог бүс нутаг. Цасны орон)

*Дулаан урсгал (Эргэн тойрноосоо өндөр температуртай далайн урсгал)

*Уур манан (Агаарт хамрагдах ус)



Япон тэнгистэй хил залгаа нутгуудад цас их ордог.



Цас их бий болох механизм

Холбогдох мэдээлэл: NHK WORLD-JAPAN, “Гадаад хэл дээрх мэдээ болон гамшгаас сэргийлэх мэдээлэл”

Гамшгаас сэргийлэх мэдээлэл болон мэдээг анхан шатны Япон хэлнээс гадна гадаадын 20 хэл дээр үзэх боломжтой.



Японы шинэ жил -Осэчи рёри (Шинэ жилийн баярын зоог) болон Нанакуса-гаю (Долоон төрлийн ургамалтай цагаан будааны зутан)-



Японы шинэ жилийн баярын зоогны төлөөлөл бол “Осэчи рёри (Шинэ жилийн баярын зоог)”. Эрт үед, Хэй-аны үед (794-1185 оны үед), кюкю/ордон дотор (Эзэн хааны амьдардаг ордон) “Сэчи ничи/улирал солигдохыг тэмдэглэх өдөр” (улирлын зааг) бурханд өргөдөг байсан зоогийг “Осэчи рёри” гэж хэлдэг байсан ба Эдогийн үе (1603-1868 он)-д энгийн ард иргэдэд түгэн дэлгэрснээр, “Сэчи ничи” дотор хамгийн чухалд тооцогддог байсан шинэ жилийн зоогийг “Осэчи рёри” гэж хэлэх болсон. Одоогийн “Осэчи рёри”-д хар буурцаг, май загасны түрс, кинтон чихэрлэг төмс, датэмаки (татсан загасны мах болон өндөгний ороомог), коохаку камабоко (хэвэнд оруулж чанасан загасны татсан мах, ягаан, цагаан өнгөтэй), сам хорхой зэрэг олон төрлийн хачирыг жюү-бако (хайрцаг хэлбэрийн,

давхарладаг сав)-нд хийж, дайлдаг.

Мөн, 1-р сарын 7-нд “Мүбё сокусай/огт өвчлөхгүй, эрүүл байх” (өвчин тусахгүй, эрүүл, цоглог амьдрах)-ыг бэлэгдэж, “Нанакуса-гаю /долоон төрлийн ургамалтай цагаан будааны зутан” иддэг заншилтай. Нанакуса-гаюд “Хаврын 7 ургамал” гэгддэг “Сэри/Water dropwort, назуна/ Shepherd's purse, горё/ Gnaphalium affine, хакобэра/ Stellaria media Cry, хотокэ-но-за /Lamium amplexicaule, сүзүна (цагаан манжингийн навч), сүзү-широ (цагаан луувангийн навч)-г хэрэглэдэг.

<Нанакуса-гаю хийх арга> Юуны өмнө 1 аяга цагаан будаа, 7 аяга ус, бага зэрэг давс бэлдэнэ. Цагаан будаагаа угаасны дараа 30 минут усанд дэвтээж, тогоо (байвал шавар тогоо)-нд хийнэ. Тогоогоо хүчтэй гал дээр тавьж, буцлахаар нь галаа зөөлрүүлэн, 40 минут орчим агшааж, будаа нь зөөлөрсний дараа татаж хэрчсэн 7 төрлийн ургамлаа дээр нь хийнэ. 7 төрлийн ургамал нь болсны дараа давсаар бага зэрэг амталж, галаа унтраан, ууранд нь хэсэг байлгавал бэлэн болно. Сүүлийн жилүүдэд супермаркет зэрэг “Хаврын 7 ургамал” багцаар нь худалдаалдаг газрууд байдаг болсон бололтой. Хийхэд хялбар тул, хийж үзээрэй!



Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)



Ур чадварын дадлагажигч, Энэ сарын зураг



Японд шинэ оноо угтсан Вьетнамын Ур чадварын дадлагажигч гоёмсог фүрисодэ (урт ханцуйтай кимоно) өмсөөд дүр хувирав! Анх удаа кимоно өмссөн төрх нь Японы сайхан дурсамж боллоо.

※2022 оны 1-р сард нийтлэгдсэн

(医療法人泉整形外科病院 介護老人保健施設コスモス)

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

[Асуудал тулгарсан үед ...?](https://www.otit.go.jp/notebook/) (<https://www.otit.go.jp/notebook/>)

ОТИТ (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばの にほんご /Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



“Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-т нийтлэхийг хүссэн сэдэв байвал бидэнд мэдэгдээрэй!

Энэхүү “Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр” товхимлын талаарх санал, сэтгэгдэл болон нийтлэхийг хүссэн сэдэв, сонирхсон сэдвээ баруун талын маягтаар илгээгээрэй.



旗のカタカナは、漢字を字音通りに読む「音読み」を示しています。指示がなかったら、「て」「みみ」「おもう」のように大和言葉訓読みとして読む方が多いかもしれませんね。
小学校で学習する「シ」と読む漢字は三十三の違う形と意味をもっています。
「シ」「シュ」にも、また三つ、四つの漢字がありますよ。



◆こくごこたえ

Туган дээрх Катакана/катакана нь ханзыг ханз үсэгнийх нь дуудлагаар дуудах “音読み/on-yomi/он-ёми/авианы дуудлага”-ыг харуулсан байна. Заавар өгөгдөөгүй бол, “て/te/тэ”, “みみ/mimi/мими”, “おもう/omou/омоу” гэх зэргээр “大和言葉訓読み/Yamato kotoba/Ямато хэл/Япон хэл/-ний күн дуудлага”-аар нь унших хүн олон байх болов уу. Бага сургуульд сурдаг “シ/shi/ши” гэж уншдаг ханз 33 өөр төрөл болон утгатай. “シ/shi/ши”, “シュ/shu/шю” ч гэсэн 3, 4 өөр ханз байгаа.

技能実習生・研修生向け母国語情報誌

技能実習生の友

2023年1月 冬季号

2023年1月1日発行

発行

電話

JITCO ホームページ

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

<https://www.jitco.or.jp/>